



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

дады оны 03 сарын 13 өдөр

Дугаар *8/38*

Улаанбаатар хот

Ж.Мөнхдууламд сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.2, 48.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.4, 10.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Жамбалжавын Мөнхдуулам албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ биелүүлээгүй нь Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дугаартай хурлын тэмдэглэл, өөрийн гаргасан тайлбар болон холбогдох нотлох баримтаар тогтоогдсон тул түүнд 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ж.Мөнхдууламд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /С.Оюун-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолモン/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН



142400846